

САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ, ХУУЛИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН ЦЭНД ОВОГТОЙ ЭРДЭНЭЦЭЦЭГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 1.1 Салбарын бодлогын болон бусад баримт бичгийг холбогдох албан хаагчидтай хамтран шинэчлэн боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулахад арга зүйн зөвлөгөө өгөх	Шинээр боловсруулсан эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулахад холбогдох нэгжид дэмжлэг үзүүлэн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэх талаар холбогдох албан хаагчид заавар зөвлөгөө өгч хамтран ажилласан байна.	1	-	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хэм хэмжээний актуудын төслийг боловсруулж, батлуулахад холбогдох албан хаагчид заавар зөвлөгөө өгч хамтран ажилласан байна. Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг баталсан Засгийн газрын тогтоолын төслийг батлуулахаар Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, ажлын даалгавар боловсруулан батлуулж, компанийг шалгаруулж, гэрээ байгуулах тушаалын төсөл боловсруулсан.	2025.01.02- 2025.06.30	90%

2.	Арга хэмжээ 1.2. Хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актыг холбогдох албан хаагчидтай хамтран боловсруулах	Арга зүйн зөвлөгөө үзүүлж хамтран ажиллах	3		Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Журам батлах тухай" А/81 дүгээр тушаалыг 2025.02.11-ний өдрийн А/35 дугаар сайдын тушаалаар хүчингүй болсонд тооцсон тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж хасалт хийлгэсэн. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2025 оны А/53,А/95,А/76 дугаар хамтарсан тушаал, 2025 оны А/130, А/58 дугаар тушаал, 2025 оны А/46, 2025 оны А/79 дүгээр тушаалууд нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд тус тус бүртгэгдсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн яаманд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн тушаалын жагсаалтыг шинэчлэн хүргүүлсэн.	2025.01.02-2025.06.30	100%
3.	Арга хэмжээ 1.3. Хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх	Хууль тогтоомж, тогтоолын төсөлд салбарын асуудлыг тусгах саналыг тухай бүр хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	3	-	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон бусад яамдаас боловсруулсан хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын тогтоолын төсөл, Сайдын тушаалд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын саналыг тухай бүрд хүргүүлж ажилласан бөгөөд нийт 59 албан бичгийг тус тус хүргүүлсэн байна. Хуулийн төсөлд-14, УИХ-н тогтоолын төсөл-1, ЗГ-н тогтоолын төсөл-25, Ерөнхийлөгчийн зарлиг-1, Ерөнхий сайдын захирамж-1, ЗГ-н хуралдааны тэмдэглэл-1, Бусад-16 албан бичиг тус тус санал өгсөн байна.	2025.01.02-2025.06.30	100%
	Арга хэмжээ 1.4. Албан хаагчдад шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээллийг тухай бүрд өгөх, шаардлагатай	Албан хаагчдад хууль эрх зүйн мэдээ, мэдээллийг тухай бүр хүргэх ажлыг зохион байгуулсан байх	1	-	Тайлангийн хугацаанд хууль тогтоомжийн талаар албан хаагчдад мэдээлэл, сургалт хийгдээгүй болно. Сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөж байна.	2025.01.02-2025.06.30	30%

	сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах						
Зорилт 2. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ”							
1.	Арга хэмжээ 2.1. Яамны дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмын төсөл боловсруулах	Журмын төслийг боловсруулан батлуулсан байна.	1	-	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”, Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-г боловсруулж, төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ахмадын санг байгуулах, ахмадын санг ажиллуулах тухай журмыг боловсруулж, төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/152, 2025 оны А/153 дугаар тушаалаар тус тус батлуулсан.	2025.01.02- 2025.06.30	100%
2.	Арга хэмжээ 2.2. Байгууллагын цахим хуудсанд захиргааны хэм хэмжээний актын бүртгэл мэдээллийг шинэчлэн байршуулах, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах	Улсын нэгдсэн санд бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээний актыг олон нийт ашиглах боломжийг бүрдүүлсэн байна. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл мэдээллийг Байгууллагын цахим хуудас болон ERP системээр байгууллагын албан хаагчид ил тод хүртээмжтэй байдлаар мэдээлсэн байна.	3	-	Яамны вэб хуудсанд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Журам батлах тухай" А/81 дүгээр хүчингүй болсон тушаалыг хасалт хийж, 2025 онд батлагдсан сайдын 5 тушаалыг нэмж байршуулсан.	2025.01.02- 2025.06.30	100%

3.	Арга хэмжээ 2.3. Сайд, төрийн нарийн бичгийн даргын эрхлэх асуудлын хүрээнд гаргасан шийдвэртэй холбогдох эрх зүйн маргааныг хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг төлөөлөн оролцох	Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилж шүүхийн байгууллагад үүссэн хэрэг маргаанд оролцсон байх	0	-	Тайлангийн хугацаанд шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг төлөөлөн оролцох хэрэг маргаан гараагүй болно.	2025.01.02-2025.06.30	50%
4.	Арга хэмжээ 2.4. Шүүх, цагдаа, эрх бүхий байгууллагаас шаардсан баримт материалыг хуулийн хугацаанд нь хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Шүүх, цагдаа, эрх бүхий байгууллагаас шаардсан баримт материалыг хүргүүлэх ажлыг зохион байгуулах	0	-	Тайлангийн хугацаанд шүүх, цагдаагийн байгууллагаас баримт, нотолгоо шаардсан албан бичиг ирээгүй байна.	2025.01.02-2025.06.30	30%
Зорилт 3. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах,	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, нэгжийн даргаар батлуулж хэрэгжүүлэх. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлүүлсэн байна.	1	-	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан нэгжийн даргад танилцуулж, батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээний биелэлтийг ханган ажилласан.	2025.01.02-2025.06.30	100%
2.	Арга хэмжээ 3.2. Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол	1	-	Удирдлагаас цохолт хийсэн албан бичигтэй тухай бүр танилцан хариу албан бичгийг хуулийн хугацаанд хүргүүлсэн. Тайлант хугацаанд 59 албан бичигт хариу хүргүүлсэн байна. Ерөнхий сайдын 2024 оны 01, 02, 03 дугаар албан даалгаврын биелэлтийг гаргасан.	2025.01.02-2025.06.30	100%

	бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж хамтран ажилласан байна					
3.	Арга хэмжээ 3.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь, бүрэн архивлах	Гүйцэтгэсэн ажлын баримтыг архивын нэгж болгон бэлтгэж, архивт шилжүүлэх	1	-	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон Монгол улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-д нийцүүлэн 2024 оны 6 дугаар сард яамнаас явсан болон ирсэн бичгийг архивт хүлээлгэн өгсөн.	2025.01.02-2025.06.30	100%
4.	Арга хэмжээ 3.4. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх	Удирдлагаас цохож шилжүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх	0	-	Тайлангийн хугацаанд өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээгүй болно.	2025.01.02-2025.06.30	100%
5.	Арга хэмжээ 3.5. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй	1.Захиргааны шийдвэрийн төсөл боловсруулах, гэрээ хэлцлийн төслийг бэлтгэх, оролцохын өмнө, үнэлгээний хороонд ажиллах, хяналт шалгалтаар явахад ашиг	2	-	Яамнаас бусад байгууллагатай гэрээ байгуулж, хамтран ажиллах талаар 8 гэрээний төслийн эрх зүйн үндэслэл, найруулгыг хянаж, холбогдох засварыг оруулсан. Гэрээний бүртгэлд 7 гэрээг шинээр бүртгэж, дугаар олгосон байна. ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлсэн байна.	2025.01.02-2025.06.30	100%

	нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	сонирхлын зөрчил үүссэн эсэх талаар мэдэгдэл, тайлбар гаргах; 2.ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлэх;					
--	---	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, багаар ажиллаж санал бодлоо илэрхийлэх	Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, хэлтсийн холбогдолтой баримт бичгийг тусгах	1	-	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/187 дугаар тушаалаар байгуулсан тус яамны 2024 оны ирсэн, явсан баримт бичиг (3 дугаар сар, 6-11 дүгээр сар)-ийг эмхлэн цэгцлэх, ангилан төрөлжүүлэх, цахим хэлбэрт шилжүүлж, архивлан байгууллагын архивт шилжүүлэх зохион байгуулах албан ажлын зайлшгүй шаардлагаар үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан байна.	2025.01.02-2025.06.30	100%
3.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах	Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, цаг ашиглалт	1	-	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлсэн. Ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаж, цаг хоцролт байхгүй болно.	2025.01.02-2025.06.30	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1.Байгууллагад зохион	Зарлагдсан сургалт, арга хэмжээнд тухай		-	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулсан Нийтийн албан тушаалтны	2025.01.02-2025.06.30	100%

байгуулж байгаа сургалт, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй хамрагдах	бүр хамрагдсан байна.	3		хууль бус хөрөнгийг хураан авах, нөхөн төлүүлэх тухай, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ын төсөл болон Арилжааны хуулийн төслийг танилцуулах хэлэлцүүлэгт оролцсон. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийн талаарх хэлэлцүүлэгт тус тус оролцсон.		
Арга хэмжээ 2. Байгууллагаас зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд тасралтгүй оролцсон байна.				Байгууллагаас зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд тасралтгүй оролцсон байна. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнд оролцож мод тарьсан.	2025.01.02-2025.06.30	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын эрх зүйн орчны шинэчлэл,
хуулийн хэлтсийн мэргэжилтэн
(Албан тушаал)

.......... /Ц.Эрдэнэцэцэг/
(Нэр, гарын үсэг)

2025 он...06 сарын...09 өдөр
(Огноо)